

ТАНИЛЦУУЛГА

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг
зохицуулах тухай хуулийн төслийн
талаар

1.Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Баялаг бүтээгч хувийн хэвшлийг дэмжсэн Арилжааны багц хууль боловсруулахаар тусгасан бөгөөд уг зорилтын хүрээнд Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслийг боловсруулахаар; Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 21 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн 2.4.3-т “Барьцаалан зээлдүүлэх газар, иргэнээс олгох зээлийн үйл ажиллагааг бүртгэл хяналттай болгож, мөнгө хүүлэлтийг тодорхойлох эрх зүйн зохицуулалтыг бий болгох” гэж, мөн өдрийн 25 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Их Хурлын 2020 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудал”-д Барьцаалан зээлдүүлэх газар, иргэд хоорондын мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл гэж тус тус тусгасан.

2.Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад энэ хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах, эсхүл хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхээр заасны дагуу хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгаанд тус үйл ажиллагааг бие даасан хуулиар зохицуулах шаардлагатай гэж тодорхойлсон болно.

Ийнхүү дээр дурдсан бодлогын баримт бичигт тусгасан зорилтыг хэрэгжүүлэх үүднээс Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хийсэн урьдчилан тандан судалгаанд тусгагдсан хэрэгцээ, шаардлагад үндэслэн хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлж, түүнд нийцүүлэн хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд зарчмын шинжтэй дараах зохицуулалтыг тусгалаа. Үүнд:

1.Иргэнээс ашиг олох зорилгоор, байнга олгох зээлийн үйл ажиллагаа болон барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхлэгчид тодорхой шаардлага тавьж, бүртгэл, хяналттай болгох, тэдгээрийг Иргэний хуульд заасан нэг удаагийн шинжтэй иргэд хоорондын зээлийн гэрээнээс ялгах /business to costumer/ болон /customer to costumer/ зарчимд үндэслэн Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

Ингэснээр иргэн, эсхүл компани бүртгэлд бүртгүүлэлгүйгээр зээлийн үйл ажиллагааг ашгийн төлөө, байнга явуулах тохиолдолд хүү авах эрхээ алдаж, холбогдох зөрчлийн хэргийн хариуцлага хүлээх нөхцөл бүрдэнэ.

2.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчид бүртгэл, хяналттай болсноор тэдгээрээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг Санхүүгийн зохицуулах хорооны дэргэд ажиллах Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөл тогтоох, дээд хэмжээ дотроо үйл ажиллагаа эрхлэгч нар өрсөлдөх зарчмыг хангахаар хуулийн төсөлд тусгалаа.

Түүнчлэн дээрх бодлогын зөвлөл мөнгөн зээлийн үйл ажиллагаанд мөрдөх бодлогыг тодорхойлох, зохицуулах, холбогдох төрийн байгууллагын үйл ажиллагааг үр дүнтэй уялдуулах зорилгоор байгуулах, бүрэлдэхүүнд Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн

захиргааны төв байгууллага, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн захиргааны байгууллага, цагдаагийн байгууллага, Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим болон салбарын эрдэмтэн, судлаачдын төлөөллийг оруулахаар хуулийн төсөлд тусгалаа.

3.Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээс олгох зээлд анзыг хэрэглэхгүй байх талаар Иргэний хуулийн 452 дугаар зүйлийн 452.2 дахь хэсэгт заасан байдаг. Энэ утгаараа зээлийн үйл ажиллагаа байнга, ашиг олох зорилгоор эрхэлж буй этгээд анз (алданги, торгууль) хэрэглэхгүй, зөвхөн нэмэгдүүлсэн хүү тооцох зарчимтай.

Гэтэл иргэнээс олгох зээлийн үйл ажиллагаа нь ашгийн төлөө, байнгын шинжтэй болж, хэт өндөр хүү тогтоохоос гадна алдангийг гэрээний үүрэг гүйцэтгэх хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0,5 хувиар тооцож зээлдэгчээс авч байна.

Ийм учраас ашгийн төлөө, байнга зээл олгох иргэдийн үйл ажиллагааг бүртгэлтэй болгосноор Иргэний хуульд заасан зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдэд тооцогдон хоног тутам алданги тооцохгүй байх, гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүү тооцох боломжтой байдлаар хуулийн төсөлд тусгасан.

5.Иргэнээс олгох болон зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүй компани зээл олгохдоо 1 хувийн шимтгэл авч байгааг бичил санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх эдгээр эрхлэгчээс олгох зээлд шимтгэл авахыг хориглохоор тусгалаа.

6.Дараагийн нэгэн чухал зарчмын шинжтэй зохицуулалт бол өдрийн зээл буюу хүүг урьдчилан авахыг хориглох асуудал юм.

Зээлдэгч зээлийг авч хэрэглэснээр ашигласан хугацааны мөнгөн дүнг зээлдүүлэгчид төлөх нь зээлийн гэрээний гол зарчим байдаг боловч өдрийн зээл нэрэн доор үндсэн зээлийг бүрэн ашиглаагүй байхад өдөр өдрөөр тооцон үндсэн зээл, хүүг зээлдүүлэгчид төлдөг зээлийн хэлбэр түгээмэл байдлаар иргэдийн дунд байнга явагдах болсон.

Тиймээс зээлийн хүүг урьдчилан авахыг хориглож, хэрэв урьдчилж үндсэн зээл, хүүг тооцож авбал Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээх байдлаар хуулийн төсөлд тусгалаа.

7.Түүнчлэн иргэнээс ашиг олох зорилгоор, байнга олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэгч, барьцаалан зээлдүүлэх газрын үйл ажиллагаа эрхлэгчид тодорхой мэргэжлийн болон бусад шаардлагыг тавьж, тус үйл ажиллагааг цаашид мэргэжлийн болгоход чиглэсэн зохицуулалтыг хуулийн төсөлд тусгав.

8.Хуулийн төсөлд зээлийн гэрээ, холбогдох барьцаа, батлан даалтын гэрээнд заавал тусгах зүйлс, гэрээг хадгалах, бүртгэх, үүнд цахим бүртгэл хөтлөх, цагдаагийн байгууллагад сэжиг бүхий барьцааны зүйлийн талаар мэдээлэх, барьцааны зүйлийг өдөр бүр цахим бүртгэлд оруулах, барьцааны зүйлийг зарж борлуулах талаарх мэдэгдэл гаргах хугацаа, хэлбэр, барьцааны зүйлийн үнэлгээний талаарх зээлдүүлэгчийн үүргийг тусгалаа.

9.Зээлийн үйл ажиллагааг зөвхөн бүртгэлтэй этгээд сурталчлах, сурталчилгаанд тавих агуулгын шаардлага, заавал тусгах мэдээлэл, үүнд зээлийн хүүгийн хэмжээ гэх мэт, зээлийн үйл ажиллагаа эрхлэгч бүртгэлийн гэрчилгээгээ

үйл ажиллагаа эрхлэх газраа байршуулах үүрэг, зээлийн хүүгийн хэмжээг ил тод баршуулах зэрэг үүргийг хуулийн төсөлд тусгав.

10.Иргэнээс ашиг олох зорилгоор, байнга олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэгч, барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхлэгчийг аймаг, нийслэлийн Засаг дарга бүртгэх, харин тодорхой мөнгөн дүнгээс дээш хөрөнгийн үнэлгээтэй, 2 болон түүнээс дээш аймагт, эсхүл аймаг, нийслэлд салбараа байгуулахыг хүссэн барьцаалан зээлдүүлэх газрын үйл ажиллагаа эрхлэгчийг Санхүүгийн зохицуулах хороо бүртгэж, холбогдох хяналт шалгалтыг хийх, хариуцлага тооцох, бүртгэлийн гэрчилгээг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох арга хэмжээ авах талаар хуулийн төсөлд тусгалаа.

11.Хуулийн төсөлтэй холбогдуулан Иргэний хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулсан.

Иргэний хуулийн 286 дугаар зүйлийн Барьцаалан зээлдүүлэх журмаар зээл олгох талаарх зохицуулалт болон Монгол Улсын стандарт MIS:5274-2017 “Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаанд тавих стандарт”-ын дагуу тус үйл ажиллагааг зохицуулж байгаа боловч хэрэгжилт хангалтгүй байгаа нь барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхлэгчдэд тавигдах шаардлага байхгүй, нэгдсэн бүртгэлгүй, эдгээр хууль, стандартын хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий байгууллага нь тодорхойгүй байгаатай холбоотой байх тул барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааны бүртгэл, хяналт, зохицуулалтын оновчтой тогтолцоог бий болгох асуудал тулгарч байгаа болно.

Түүнчлэн иргэнээс олгох зээлийн үйл ажиллагааны тухайд Иргэний хуулийн 281-285 дугаар зүйлд заасны дагуу зохицуулж байгаа хэдий ч ашгийн төлөө, байнга болон нэг удаагийн шинжтэй зээлийн үйл ажиллагааг зарчмын хувьд ялгаагүй ерөнхий байдлаар хуульчилсан байгаагаас шалтгаалан бүртгэл, хяналтгүйгээр иргэнээс олгох зээлийг ашгийн төлөө, байнга хийхдээ зээлийн хүүг хэт өндөр буюу сарын 5-12 хувийн хүүтэйгээр, хугацаа хэтэрсэн үүргийн гүйцэтгэлд хоног тутам 0.5 хувийн алданги тооцон, барьцааны зүйлийг зээлдүүлэгчийн тогтоосон ханшаар үнэлэн зарж борлуулах, гэрээ байгуулсны шимтгэл 1 хувиар тооцон зээлдэгчээс авах зэргээр зээлдэгч буюу санхүүгийн хэрэглэгчийн эрхийг ноцтой зөрчиж байна.

Харин тус хуулийн төсөл батлагдсанаар дараах үр дагавар бий болно. Үүнд:

- Бичил санхүүгийн хэрэглэгч буюу зээлдэгчийн эрх ашгийг хамгаална. Үүнд, зээлийн хүүгийн дээд хэмжээний дотор хүү төлөх, анз (алданги, торгууль) төлөхгүй, шимтгэл төлөхгүй байх гэх мэт;
- Эдгээр үйл ажиллагаа эрхлэгчийн нэгдсэн бүртгэл бий болсноор мөнгөний эргэлт нь тодорхой болж, улсын төсөвт төлөх татвар шударгаар төлөгдөх нөхцөл бүрэлдэнэ;
- Нийт гэмт хэргийн 60 орчим хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг эзэлдэг бөгөөд үүний 30 гаруй хувийг хулгайн гэмт хэрэг эзэлдэг, мөн гэрээгээр халхавчилсан залилангийн хэрэг түгээмэл гардаг тул эдгээр төрлийн гэмт хэрэг, түүнчлэн эдгээр үйл ажиллагаа эрхлэгч нарын үйл ажиллагааг

бүртгэл, хяналттай болгосноор мөнгө угаах, татвар төлөхөөс зайлсхийх гэх мэт эдийн засгийн гэмт хэрэг буурахад нөлөөлнө;

- Бүртгэлгүйгээр ашгийн төлөө, байнга зээл олгох үйл ажиллагаа эрхэлж буй иргэд, хуулийн этгээдэд хариуцлага тооцож, хүү авах эрхгүй болсноор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх салбар мэргэжлийн, хариуцлагатай болж, бүртгэлгүй иргэд татвар төлөхгүйгээр, дур зоргоороо хүү, алданги тогтоон ашиг олох үйл ажиллагаа хумигдана.

Бусад улс орны тухайлбал, эх газрын бүлийн улсууд болох Япон Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Эстони, Гүрж, Швед, англо саксоны бүлийн улсууд болох Сингапур, Малайз, , Ирланд, Англи, Канад, АНУ-ын Аризона муж, Ямайка мөн түүнчлэн африкын Намибиа улс, холимог тогтолцоо бүхий Тайланд гэх зэрэг улсуудын туршлагаас харахад, банк, санхүүгийн байгууллагаас гадна барьцаалан зээлдүүлэх газар болон иргэнээс олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчдийг бүртгэх, зөвшөөрөл олгох тогтолцоог хэрэгжүүлж, мөнгө зээлүүлэх үйл ажиллагааг зөв зохион байгуулах, улмаар бизнесийн зохистой үйл ажиллагааг дэмжих, нөгөөтэйгүүр санхүүгийн хэрэглэгчдийн ашиг сонирхлыг хамгаалах харилцааг тусгайлан зохицуулсан хууль (Moneylending Business Act, Interest Limitation act, Microcredit act, Consumer credit act, Pawnbrokers act)-иар зохицуулдаг байна.

Үүнд голчлон бага хэмжээний мөнгөн зээл буюу хэрэглээний зээл, эсхүл хувь хүнд олгох зээл хамаарах бөгөөд зээлийн хүүгийн дээд хязгаарыг хуулиар тогтоосон байна. Түүнчлэн бүртгэлд тавигдах шаардлагыг зөрчсөн, тогтоосон зээлийн хүүгийн дээд хэмжээнээс хэтрүүлэн хүү тогтоосон зэрэг үйлдэлд торгох, хорих ялаар шийтгэх талаар зохицуулсан байна.

Хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/135 дугаартай тушаалаар байгуулсан ажлын хэсэг боловсруулсан бөгөөд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Сангийн яам, Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо, татвар, бүртгэл, прокурор, цагдаа зэрэг байгууллагын төлөөлөл орсон болно.

Хууль тогтоомжийн тухай хуульд заасан урьдчилан тандан судалгаа, харьцуулсан судалгаа, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хөндлөнгийн багаар хийлгүүлж, зөвлөмжийг тусган ажиллалаа.

Түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төсөлд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахаар хуулийн төслийг үзэл баримтлал, танилцуулгын хамт Хууль зүй, дотоод хэргийн яамны цахим хуудсанд 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдөр байршуулсан бөгөөд үүний дагуу иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн саналыг хүлээн авч, хуулийн төсөлд анхаарч тусгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт заасны дагуу Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөлд санал авахаар сайд нар болон 12 холбогдох байгууллагад 2020.10.01-ний өдрийн 1/1035 тоот албан бичиг хүргүүлсэн бөгөөд үүний дагуу ирүүлсэн саналыг хүлээн авч хуулийн төсөлд анхаарч тусган ажиллаа.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР